



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2022 оны 10 сарын 13 өдөр

Дугаар 485

Улаанбаатар хот

Удирдамж болгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 6, 21 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 65 дугаар зүйл, Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 3.1.3 дахь заалт, Авлигатай тэмцэх газрын 2022 оны 05/13339 дүгээр албан бичгээр ирүүлсэн дүгнэлтийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүдэд дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг удирдамж болгосугай.

1.1 “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирлаар Ганпүрэвийн Дугаржавыг томилох асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх.

1.2. “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Ганпүрэвийн Дугаржавтай Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээг хууль тогтоомжийн дагуу байгуулж ажиллах.

2. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ